**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 30 өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2017 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 1.8, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтэц"-ийг хавсралтаар шинэчлэн батлагдсугай.

2. Тогтоолд нийцүүлэн бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн баталж, хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. "Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтэц"-ийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны "Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн батлах тухай" 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд үүрэг болгосугай.

ДАРГА Т.МӨНХСАЙХАН

1117149846
ТҮ30045 д 5264708

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн
2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 14 дугаар
тогтоолын хавсралт



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

